



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/82

Хэрлэн сум

Авто машиныг худалдан авахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоол, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. E-MONGOLIA системийн ач холбогдлыг сурталчлан таниулж, төрөөс иргэд олон нийтэд “ХУРДАН” төвөөр дамжуулан үзүүлж буй цахим үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх зорилгоор явуулын цахим үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглол бүхий авто машиныг худалдан авахад 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн иргэдэд биечлэн үйлчилгээ үзүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

А/82
Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 20-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Бүгд үнэ
1	Явуулын цахим үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглол бүхий авто машин	20,000,000
	Нийт	20,000,000